МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 23 өдөр Дугаар А/604 Мөрөн сум

Арга хэмжээ зохион байгуулж,
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын 2023 оны 279 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй "Хүнсний хувьсгал" үндэсний хөдөлгөөн, Засгийн газрын 279 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Улаанбаатар хот болон, аймгийн төвийн хүн амын өвөл, хаврын улирлын махны нөөцийг бүрдүүлэх зорилгоор "Өвлийн идэш" арга хэмжээг 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдрөөс 12 дугаар сарын 03-ны өдрүүдэд Улаанбаатар хот болон Мөрөн суманд зохион байгуулсугай.

2.Тус арга хэмжээг зохион байгуулах, бэлтгэл ажлыг хангуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

3.Арга хэмжээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг өргөн хүрээтэй хамруулж, оролцохыг сумдын Засаг дарга нарт, арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (М.Хуягбаатар)-д, тус тус даалгасугай.

4.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т үүрэг болгосугай.

ДАРГА П.ЛХАГВАЖАВ

Захирамж-2023

6712011404

Аймгийн Засаг даргын 2023 оны 11
дугаар сарын 23- ны өдрийн А/604
дугаар захирамжийн хавсралт

"ӨВЛИЙН ИДЭШ" АРГА ХЭМЖЭЭГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч: М.Хуягбаатар (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүдэд: Б.Оюунтуяа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)
Б.Базар (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга)
Я.Эрхэмбаяр (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)
Л.Ариунаа (Мал эмнэлгийн газрын дарга)

А .Алтанцоож (Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн хурандаа)
Х.Тайванбаяр (Мөрөн сумын Засаг дарга)

Б.Баярсайхан (Биеийн тамир, спортын газрын дарга)

С. Мөнх-Эрдэнэ (Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв ХХК-ийн гүйцэтгэх захирал)

Ө.Баттулга (Аймгийн авто тээврийн төвийн дарга)

Б.Алтанхуяг (Уран алдар хайрхан махны үйлдвэрийн захирал)

Сумдын Засаг дарга

Хэвлэл мэдээллийн байгууллагууд

Нарийн бичгийн дарга: Б.Цолмонбаяр (Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын үйлдвэр, худалдаа, үйлчилгээний албаны дарга)

----------oOo----------